



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2024.07.24 № 626

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

### Г ХАНДИВЫН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ Г

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ардчилсан намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай Хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

#### **Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ардчилсан намын хороо нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ардчилсан намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын

23242665

Ерөнхий аудиторовын 2024 оны тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

### ***Дүгнэлт***

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Ардчилсан намын хороо нь 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР